


## Уншигч судлаач та бүхэндээ зориулж “Тогтмол хэвлэлийн сан хөмрөгт” буй Орос сэтгүүлийг цувралаар толилуулж байна. Цуврал №3





### Ботанический журнал СССР

Оросын Ботаникийн Нийгэмлэг, Оросын ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгээс эрхлэн гаргаж байсан ургамлын янз бүрийн салбарын судлагаа шинжилгээний үр дүнг нийтэлдэг сэтгүүл. 1916 оны 12-р сард Оросын Ботаникийн нийгэмлэгийн сэтгүүл нэртэйгээр анхны дугаар нь гарчээ. Үүнээс хойш сэтгүүлийн нэр хэд хэдэн удаа солигдсон бөгөөд 1932-1947 онд “ЗХУ-ын Ботаникийн сэтгүүл” нэрээр гарч байв. 1932-1940, 1942-1992 оны дугаарууд

### Биология, медицина, физкультура

Уг сэтгүүлийг Москва дахь номзүйн хүрээлэнгээс эрхлэн гаргаж байв. Тус сэтгүүлд биологи, эрүүл ахуй, сэтгэл зүй, невропатологи, сэтгэцийн эмгэг судлал, эм зүй, анагаах ухаан, биеийн тамирын чиглэлээр шинэ тутам гарсан номын танилцуулгыг нийтэлдэг байв. 1935 №1-12 дугаарууд



### Бюллетень экспериментальной биологии и медицины

Уг сэтгүүлийг 1936 оноос Оросын Анагаах ухааны Академиас эрхлэн гаргаж байсан сар тутмын шинжлэх ухаан-онолын сэтгүүл. 1936-1941, 1943-1947, 1955-1963, 1965-1966, 1968-1973, 1976-1978, 1982, 1984, 1987-1991 оны дугаарууд

## Биология в школе

1927 оноос Зөвлөлтийн Гэгээрлийн яамнаас эрхлэн гаргаж байсан шинжлэх-ухаан арга зүйн сэтгүүл. Жилд 8 дугаар гарч байв. 1937, 1939-1941, 1957-1994 оны дугаарууд



## Биохимия


ЗХУ-д биохимийн ухааны хөгжүүлсэн проф. А.Н. Бахын хүчин зүтгэлээр 1936 онд тус сэтгүүл анх хэвлэгдэж эхэлжээ. 1956 оноос хойш энэ сэтгүүл англи хэл рүү орчуулагдан гарах болсоноор биологийн ухааны нэр хүндтэй сэтгүүлий нэг болжээ. Сэтгүүл нь физиологи, молекул биологи, микробиологи, биохимийн асуудлаарх судалгааны үр дүнг нийтэлдэг. Өдгөө ч тус сэтгүүл хэвлэгдэн гарсаар байна. 1938-1940, 1942-1952 оны дугаарууд



## Биологический журнал


Байгаль шинжлэлийн утхай цувралаар гардаг сэтгүүл. 1936, 1938 оны дугаарууд Библиография изобразительного искусства

ЗХУ-д 6 хоногт нэг удаа гардаг байсан “Книжная летопись” сэтгүүлд 1939 онд хэвлэлээс гарсан дүрслэх урлагийн талаарх ном хэвлэлийн тойм бүртгэл. 1939 оны №1-4 4ш дугаарууд



## Библиография картографической литературы и карт

ЗХУ-д 6 хоногт нэг удаа гардаг байсан “Книжная летопись” сэтгүүлд 1939 онд хэвлэлээс гарсан газрын зураг зүйн ном зохиол хийгээд газрын зургуудын тойм бүртгэл. Тус сэтгүүлээс өдгөө нэгэнт үгүй болсон эсвэл нэр нь өөрчлөгдсөн Ойрдын Өөртөө Засах Орон (Ойротская автономная область), Буриад Монголын Өөртөө Зах Улсын (Бурят-Монгольская АССР) газрын зургийн талаар бүртгэлээс мэдэж болно. 1939 оны №4 2ш дугаарууд



## **Бумажная промышленность**

1922 онд анхны дугаар нь хэвлэгджээ. Зөвлөлтийн Ойн аж үйлдвэрийн яамнаас эрхлэн гардаг сар тутмын үйлдвэрлэл техникийн сэтгүүл. 1939, 1947-1951, 1954-1958, 1960-1973, 1984, 1991 оны дугаарууд

## **Большевистская печать**

БХК (б)Н-ын Төв Хорооны хэвлэл, хэвлэлийн асуудлаар гардаг төрөлжсөн сэтгүүл. 1933-1941 онуудад сард 2 удаа тогтмол гарч байв. 1940, 1941, 1989, 1990 оны дугаарууд

